

Хүүхдэд зориулсан Библи танилцуулж байна



Рут :
Хайрын
ТҮҮХ



Зохиогч: Edward Hughes

Зураглаач: Janie Forest

**Найруулсан: Lyn Doerksen
Alastair P.**

Орчуулсан: Damdin Norolsuren

Бүтээсэн: Bible for Children

www.M1914.org

BFC

PO Box 3

Winnipeg, MB R3C 2G1

Canada

©2022 Bible for Children, Inc.



**Зөвшөөрөл: Та энэ бүтээлийг хувилах хуулах
эрхтэй харин худалдахыг хориглоно.**



Хэрэв та өөрийн элэнц өвөг бүр тэдний эцэх эх бас гэр бүлийнхээ бүр өмнө нь амьдарч байсан бүх хүмүүстэй уулзана гэвэл та үнэхээр их гайхаж тэд ямар хүмүүс байсан болоо гэж та үнэхээр их сонирхох байсан байхаа. Библи дээр Есүсийн угийн бичигт Рут гэдэг хиймэл шүтээн шүтдэг байсан Моаб эмэгтэй бичигдсэн байдаг.




**Рутын түүх бол Самсоны үеэс хойш Бурханы
ард түмэн Бурханд итгэж бас дуулгавартай байхаа
больсон үед Израильд болсон түүх юм. Аймшигтай
өлсгөлөн газар нутгуудад тархав. Та нар
өлсгөлөн гэж юү болохыг мэдэх үү?
Тийм ээ зөв! Өлсгөлөн гэдэг нь ямар
ч жимс бас ургац байхгүй болоход
амьтан зарим үед бүүр хүн ч
өлсөж үхэж болно.**



Елимелех гэдэг нэгэн хүн Бетелхемээс гаран өөрийн эхнэр хоёр хүүтэйгээ хоол хүнс хайж явав. Тэр хиймэл шүтээнд мөргөдөг Моаб нутагт ирэв.



**Елимелех
болон түүний
гэр бүлийн хувьд түүний амьдрал Моабд
ирээд сайн байсангүй. Тэр тэнд хоёр хүүгийнхээ
араас нас
барав.**



**Түүний эхнэр Наоми түүний хоёр
хүүгийн эхнэр болох Рут Орпа нар үлдэв.
Хоёр бэр нь хоёулаа Моаб охид байв.**



Наоми одоо тэр бэлэвсэн болж Эзэн өөрийн хүмүүс дээр ирж хоол хүнс өгч буйг сонсов. Тэр эмэгтэй нутагруугаа буцахаар шийдэв. Гэвч хоёр бэр нь хаачих вэ? Наоми тэдэнд Моаб нутагтаа үлдээд дахин гэрлэхийг зөвлөв.



Орпа өөрийн төрсөн гэртээ буцав. Харин Рут буцаж очихоос татгалзав. Үүний оронд Рут хайрын үг хэлж тэр өөрийн хадам эхийг хэзээ ч орхихгүй гэж амлав.







Наомиг төрөлх хот Бетелхемдээ очиход түүний найзууд нь талархаж хүлээж авав. Гэвч тэр эмэгтэй намайг Наоми гэж дуудах хэрэггүй Мара гэж дууд

гэлээ. "Төгс Хүчит Нэгэн надад хэрцгий хандсан" гэв. Наоми өөрийн бэр Рутаас өөр юу ч үгүй буцаж иржээ.



Рут Моаб нутагтаа байхдаа хиймэл шүтээнд мөргөдөг байсан ч тэр эмэгтэй түүнээсээ эргэж Израилийн амьд Бурханд мөргөдөг болов. Рут Наомиг хангалтай хооллохын тулд шаргуу ажиллаж байлаа. Тэр өдөр бүр тариан талбайд очиж хаягдсан түрүүг түүдэг байв.






**Тариан талбайн эзэн
Боаз Рутын тухай тэр
хэрхэн өөрийн хадам
эхэд сайн хандаж
байгааг сонсов. Тэр
Руттай уулзаад Боаз
өөрийн тариа хураагч
нартаа хаягдсан тариан
түрүүг түүхэд түүнд бүү
саад болоорой хэмээн
захив. Рут Боазид
таалагдаж эхлэв.**





**Рут Наомид
Боазын сайхан
сэтгэлийн тухай
хэлэхэд настай
эмэгтэй
Бурханыг
магтав.
"Тэр хүн бол
манай ойрын
төрлийн хүн
хамаатнуудыг
нэг юм" гэв.**






**Цаг хугацаа өнгөрч
Боаз Руттэй хурим
хийж Наоми
болон түүний
гэр бүлийн
газрыг
хариуцахыг
хүсэв. Гэвч**

**хамгийн ойрын хамаатан болох нэг
хүнд энэ нь боломжтой байв. Тэр хүн
газрыг нь авахыг хүсэж байснаас
Руттай гэрлэхийг хүсэхгүй байв.
Хуульд тэр хэн түүнийг авах хүсэлтэй
хэн нэгэн байх хэрэгтэй гэсэн байв.**



Тэр өдрүүдэд ямар нэг гэрээ хийгээд хоорондоо гар барьдаггүй байв. Боаз гутлаа тайлж олон хүний өмнө үүнийг тэр хүнд өгөв. Ингээд ажил хэрэг амжилттай болов. Рут түүний эхнэр болов.



**Одоо Рут болон Наоми
Боазын гэр бүлийн
гишүүд болсон.**



**Боаз Рут нар анхны
хүүгээ Обед гэж нэрлэв.
Тэрээр Израилийн агуу
хаан Давидын өвөг эцэг
болсон юм.**



**Гэвч хамгийн гайхамшигтай нь бяцхан хүү Обед мөн
Эзэн Есүс Христийн удмын өвөг эцэг юм. Есүс
Давидын удмаас төрсөн энэ дэлхийн Аврагч бас
хаадын Хаан юм.**



Рут : Хайрын түүх


Бурханы үг Библиээс авсан түүх

Рут

"Таны үгсийн тунхаглал гэгээрүүлдэг."

Дуулал 119:130





16



60



Библийн түүх нь гайхамшигт Бурхан биднийг бүтээсэн бөгөөд таныг өөрийгөө мэдээсэй гэж хүсдэг тухай бидэнд хэлдэг.

Бурхны гэм гэж нэрлэдэг муу зүйлийг бид үргэлж хийдгийг Бурхан сайн мэднэ. Гэмийн шийтгэл нь үхэл боловч Бурхан танд маш их хайртай учир Тэрээр цорын ганц хүү Есүсийг таны гэмийн өмнөөс шийтгүүлэн загалмайд цовдлогдон үхэхийг зөвшөөрөн энэ дэлхийд илгээсэн юм. Тэгээд Есүс дахин амилж тэнгэр дэх гэртээ буцсан! Хэрвээ та Есүст итгэж түүнээс гэмийнхээ төлөө уучлал гуйвал Тэрээр таныг уучлах болно! Тэрээр таньруу ирэх бөгөөд тантай хамт байх болно мөн та түүнтэй мөнхөд хамт амьдрах болно.

Хэрвээ та энэ үнэнд итгэж байвал Бурханд хандан ийнхүү хэлээрэй: Эрхэм Есүсээ, Би таныг Бурхан гэдэгт болон миний гэмийн төлөө үхсэн гэдэгт мөн одоо та амьд гэдэгт итгэж байна. Миний амьдралд орж ирээд миний гэмийг уучлаач, тэгээд Би одооноос эхлээд шинэ амьдралаар амьдарч нэг өдөр тантай хамт мөнхөд байхаар явах болно. Танд дуулгавартай байж таны хүүхэд шиг таны төлөө амьдрахад туслаач. Амен.

Библи уншиж өдөр бүр Бурхантай ярилцаарай! Иохан 3:16

